

“БАЯНХОНГОР АЙМГИЙГ 2021 - 2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН
ИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

ЧИГЛЭЛ” -

Д/Д	заалтын дугаар	Бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ [1]	Төсөв[2] /сая төг/		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт[3]	Суурь түвшин[4]		Зорилтот түвшин[5]		Хэрэгжилт[6]	Хүрээлэн түвшин буюу гүйцэтгэлийн үнэмлэхүй үнэ[7]
			Төсөвлөсөн	Гүйцэтгэл		Он	Түвшин	Он	Түвшин		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Зорилго 1. Үндэсний нэгдмэл бахархалыг сэргээж, эх хэл, хонгор нутгийнхаа түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдэлийг эрхэмлэсэн хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.											Монгол
1	1.	Зорилт 1. Соёлын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, өсвөр үе залуучуудад сурталчлан таниулах, соёлын салбарын хүний нөөцийг чадвхижуулна.			мэргэжлийн урлагийн байгууллагын ажилчдын ажилтчдын тоо	2020	45 хувь	2021	57 хувь	Бүх нийтийн соёлын боловсрол"-ыг дээшлүүлэх, "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд аймгийн Соёлын хэлтсээс Хөгжимт драмын театрын уран бүтээлчидтэй бүрэн бүрэлдэхүүнээрээ бүх сумуудаар "Тэнгэрлэг түмний дуулал" аялан тоглолт, "Яруусахуйн амирлал" яруу найргийн цэнгүүн, "Уран жиргээ, "Их Богдын эгшиглэн" өсвөрийн болон насанд хүрэгчдийн яруу найргийн наадам "Бидний бахархах- мэргэжилтэн" төрийн захиргааны албан хаагчид оролцсон урлагийн тоглолт зэрэг иргэд олон нийтийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн 10 гаруй олон талт ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Мэргэжлийн урлагийн байгууллагад 230 гаруй ажилтан албан хаагч ажиллаж байгаа ба боловсон хүчний судалгаа 45 хувьтай байсан бол 2021 онд 19 сум 4 мэргэжлийн урлагийн байгууллагаас мэргэжлийн бус 20 соёлын ажилтан Боловсролын их сургуулийн хөгжмийн багшийн эчнээ ангид суралцаснаар 57 хувьтай болоод байна. Эрдэнэцогт, Жаргалант сумын хөгжмийн багш Соёл урлагийн их сургуулийн хөгжмийн багшийн ангид суралцаж байна. Соёл урлагийн байгууллага нь мэргэжлийн боловсон хүчнээр хангагдснаар салбарын үйл ажиллагаа сайжирч бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэхэд тодорхой үр дүн гарна.	70
2	1.1	Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна.	20	20	Үл хөдлөх дурсгалт газрын хадгалалт хамгаалалтыг сайжруулсан газрын тоо	2020	0	2021	10	Улсын хамгаалалтай 12, аймгийн хамгаалалттай 57 нийт 69 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрыг ард иргэдэд гэрээгээр хариуцуулах ажлыг холбогдох хуулийн дагуу гурвалсан гэрээ байгуулж ажиллахаар шийдвэрлэсэн. Орон нутгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалан сурталчлах талаар аймгийн Засаг дарга Соёлын, сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсанаар сум тус бүрийн гэрээнд тодорхой газруудыг нэр зааж тусгаж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар 19 сумын 10 Түүх соёлын үнэд хадгалагдах дурсгалт газруудад хайс хамгаалалт хийлээ. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 10 шинээр бүртгэсэнээр аймгийн бүртгэл мэдээллийн санд өвлөн уламжлагч 305 бүртгэгдлээ. Түүх соёлын үнэд хадгалагдах дурсгалт газруудыг хайсжуулж хадгалалт хамгаалалтыг сайжруулснаар мал амьтан, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс сэргийлж хадгалалт хамгаалалт сайжирна. Мөн аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1 дахь заалтын дагуу 2024 он хүртэл үе шаттайгаар 69 түүх соёлын үнэд хадгалагдах дурсгалт газруудын хайс хамгаалалтыг сайжруулж бүрэн хамгаалалтанд авсан байна.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
3	1.2	Соёл урлагийн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тэдний ур чадвар, ажиллах орчин нөхцлийг сайжруулна	0	0	Мэргэжилтэй ажилтны хангалтын хувь	2020	37%	2021	50%	Монгол улсын Соёлын яам, Үндэсний номын сангаас зохион байгуулсан “Номын сангийн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт” цахим сургалтад аймгийн Нийтийн номын сангийн номын санчдыг 3 удаа хамруулсан. Соёлын яам, Соёл урлагийн их сургуультай хамтран салбарын нийт 120 гаруй соёлын ажилтнуудын мэргэжил боловсролыг дээшлүүлэх 2 кредитийн сургалтыг мэргэжил тус бүрээр 2021 оны 11 дүгээр сарын 07- 13-ны өдөр зохион байгуулав. Сургалтаас олж авсан мэдлэг бататгах цахим шалгалтад амжилттай суралцсан соёлын ажилтнуудад “Батламж” олгосон. Мэргэжлийн урлагийн байгууллагуудаас 12 Соёлын төвийн эрхлэгчийн сул ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлуулах Төрийн албаны салбар зөвлөлд саналыг хүргүүлээд байна.Түүх угсаатны зүй байгалийн музейн ажилтнуудыг “Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021”, “Музейн үзүүлэг дэглэлт, чанар хүртээмжийг олон улсын стандартад хүргэх боломжийн тухай” сургалтад хамруулан мэдлэг чадварыг нь	70
4	1.3	Соёлын салбарын бүтэц, тогтолцоог боловсронгуй болгож, иргэдийг соён гэгээрүүлж, хандлагыг өөрчлөх замаар хувь хүний, гэр бүлийн, байгууллагын соёлын дархлааг нэмэгдүүлж, “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	27.8	27.8	Соелтын хэлтэс байгуулсан байна	2020	0	2021	1	Аймгийн Засаг даргын 2021 оны А/626 тоот захирамжаар Соёлын хэлтсийг 5 хүний орон тоотойгоор баталж үйл ажиллагааг эхлүүлсэн. Соёлын яам, Боловсрол соёл урлагийн газар аймгийн соёл урлагийн байгууллагууд “Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “ИРЭЭДҮЙН АМЖИЛТЫН ЭЗЭН” хүүхдүүдэд зориулсан өв соёлыг түгээн дэлгэрүүлэх агуулга бүхий контент хийх ажлыг Байгалийн музейн Тарбозаврын танхим, Түүх угсаатны зүйн музейг түшиглэн хийж МҮОНРТ, болон аймгийн телевиз, мэдээллийн хэрэгслээр улс орон даяар сурталчиллаа. Мөн МУИС-ын ШУ-ны танхим, Дижитал Солюшнс ХХК-ны хамтран бүтээсэн Занабазарын гайхамшигт урлагийн бүтээлүүд, хүний биеийн анатомын бүтэц, нарны аймгийн систем, физикийн цахилгаан орон ба соронзон орны зэрэг 4 контентыг багтаасан виртуаль музейн төхөөрөмж-1ш, түүх угсаатны зүйн музейд-2ш, Байгалийн түүхийн музейд-2 ш нийт 4VR-box төхөөрөмжөөр галзуу хулгана, динозавр, хурдны зам, авто машины уралдаан зэрэг 5 ширхэг, 9 төрлийн контентоор дамжуулан орчин үеийн дэвшилтэд техник тоног төхөөрөмжийг байрлуулан, дижитал орон зай бий болгон виртуал үзмэрүүдийг иргэд, хүүхэд залуучуудад үйлчилж байна.	70
5	1.4	Соёл, урлагийн байгууллагуудын барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, соёлын төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, иргэн бүрт хүрч үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	79	79	Шинээр баригдсан соёлын байгууллага, тоног төхөөрөмжийн хангалтын хувь	2020	73 хувь	2021	85 хувь	Бууцагаан, Богд, Жинст, Заг, Эрдэнэцогт, Галуут, Гурванбулаг зэрэг сумдын соёлын төв бүрэн ашиглалтанд орсон. Баянлиг, Хүрээмарал, Өлзийт сумдын соёлын төвийн барилгын ажлын явц 80 хувийн гүйцэтгэлтэй, халаалт хийгдэж дууссан. Дотор заслын ажил хийгдэж байна. 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор ашиглалтанд орно.Гурванбулаг, Баян-овоо, Бууцагаан сумын соёлын төвүүд сум орон нутагтаа цалингийн санг шийдвэрлэн орон нутаг судлах танхимын ажилтныг авч ажиллуулж байна. 2022 оны төсвийн төсөлд тусгаж холбогдох газарт хүргүүлсэн. Мөн Гурванбулаг, Бууцагаан, Бөмбөгөр, Эрдэнэцогт, Заг, Богд, Жинст зэрэг сумдад Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 79 сая төгрөгний үзэнгийн сандал, номын сангийн ширээ, сандал, офисс ширээ сандал ханын шүүгээ зэрэг хөрөнгө оруулалт хийсэн. 2022 онд шинээр ашиглалтанд орсон 4 сумын соёлын төвийн тавилга эд хогшлийг шийдвэрлүүлэхээр Соёлын яамд уламжлаад байна. Соёлын төв ажиллах нөхцөл боломжоор хангагдсанаар иргэдийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөл бүрдэж сумдын барилга байгууламж, техник хэрэгсэл, эд хогшлийг уншлагад 85 хувьд хүрсэн	100
6	1.5	Иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлж, сумдын номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулна	0	0	Номын сангаар үйлчлүүлсэн иргэдийн тооны ахилт	2020	271	2021	356	Иргэдийг соён гэгээрүүлэх цахим уншлага үйлчилгээг тогтмолжуулж Хүүхдийн уншлагын танхимаас уншигч хүүхэд багачуудад зориулсан үлгэр, домог 134, нийтийн уншлагын танхимаас танин мэдэхүйн төрөл бүрийн мэдээлэл 86, гэрээр ном олгох танхимаас 67 зохиол, “Цахим уншлага” пэйж хуудсанд 177 зохиол тус тус нийтэлж уншлага, үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэж ажиллаа	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
7	1.6	Аймгийн түүхийн музейн барилгыг ашиглалтад оруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн биет болон биет бус өвийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулна..	0	0	Мэдээллийн сангийн баяжилт	2020	0	2021	7785	Музейн стандартад нийцсэн зориулалтын шинэ барилга баригдхааргүй болсон боловч 2022 онд 20.0 сая төгрөгний тохиолол, камержуулах ажил хийгдхээр жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан. Бүртгэл мэдээллийн сангийн хөдлөх дурсгал үзмэрийн баяжилтыг RCH программд 400 нэмэгдүүлэн ажиллаа. RICH бүртгэлийн программд 7785 дурсгал бүртгэлтэй байдгаас 11 хүн чулуун хөшөө байна.	70
8	1.2.	Хүүхэд, залуучуудын эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлж, Монгол ахуй, ёс заншил, өв уламжлал, хэл бичгийн хэрэгцээг нэмэгдүүлнэ. Хүүхдийн хөгжил,								хэрэгжээгүй	0
9	1.2.1	Төлөвшилийг сайжруулж, монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болгож, эцэг, эхийн үүрэг оролцоо, харивцлагыг								хэрэгжээгүй	0
10	1.2.2	Хүүхэд, залуучуудын Монгол хэл бичгийн чадварыг дээшлүүлж, "Цахим соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.								хэрэгжээгүй	0
<p>Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.</p>											
11	2.	Зорилт 2. Хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлж, боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлнэ.	18.569.0	18.569.0	Сурлагын чанарын үнэлгээ Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх	2020	амжилт 45%, 5000 хүүхдийн 13 сургууль, 1000 хүүхдийн 11 цэцэрлэг, 475 хүүхдийн 4 дотуур байрыг тус тус	2021	амжилт 45% 2 сургууль 1 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах	Суурь боловсролыг 1227 хүүхдэд олгож, 18800 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. Сургуульд суурилсан үнэлгээгээр 37 хувийн амжилттай үнлэгдэсэн нь өмнө оноос буурсан үзүүлэлтэй байгаа нь цар тахлын улмаас хүүхдийн сурлагын хоцрогдолтой бий болсонтой холбоотой байна. Аймгийн хэмжээнд боловсролын салбарт 18.529.1 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 сургуулийн хичээлийн байр, 1 цэцэрлэгийн байрыг тус тус ашиглалтад оруулж, 2021 онд элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан сурагчид болон багш нарыг урамшуулах тогтолцоо бүрдүүлж, болзлыг хангасан 8 багш, 9 сурагч, мөн Дэлхийн том хичээл-Тогтвортой хөгжлийн боловсрол-II хэлэлцүүлэгт тэргүүн байр эзэлсэн 3 багшид 19.2 сая төгрөгийн урамшуулал олгосон. Мөн хувийн "Төгс алгоритм" сургууль нь элсэлтийн шалгалтын дүнгээр улсад 1 дүгээр байр эзэлж 2.0 сая төгрөгийн компьютер, улс аймгийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан 20 багшид 5.8 сая төгрөгөөр урамшуулсан. БШУЯ, Багшийн Хөгжлийг Дэмжих Боловсрол Сан, ЮНЕСКО Монголын Үндэсний Комисс хамтран зохион байгуулж буй Дэлхийн Шилдэг Багш 2022 шалгаруулалтад нэр дэвших "ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ 10 БАГШ" -д Багш нарын өмнөд үндэсний лаборатори	70
12	2.1	Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	25	24.8	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2020	"Сайн багш" хөтөлбөр 90 хувь хэрэгжсэн, СӨБ-ын багшийн хангалт 95.4, ЕБС-ийн 99.4	2021	төлөвлөгөөний хэрэгжилт 25 хувь	сурагчид болон багш нарыг урамшуулах тогтолцоо бүрдүүлж, болзлыг хангасан 8 багш, 9 сурагч, мөн Дэлхийн том хичээл-Тогтвортой хөгжлийн боловсрол-II хэлэлцүүлэгт тэргүүн байр эзэлсэн 3 багшид 19.2 сая төгрөгийн урамшуулал олгосон. Мөн хувийн "Төгс алгоритм" сургууль нь элсэлтийн шалгалтын дүнгээр улсад 1 дүгээр байр эзэлж 2.0 сая төгрөгийн компьютер, улс аймгийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан 20 багшид 5.8 сая төгрөгөөр урамшуулсан. БШУЯ, Багшийн Хөгжлийг Дэмжих Боловсрол Сан, ЮНЕСКО Монголын Үндэсний Комисс хамтран зохион байгуулж буй Дэлхийн Шилдэг Багш 2022 шалгаруулалтад нэр дэвших "ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ 10 БАГШ" -д Багш нарын өмнөд үндэсний лаборатори	100
13	2.2	Тусгай хэрэгцээт боловсролын анги, бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, багшлах боловсон хүчнийг бэлтгэн, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ.	0	0	Тусгай хэрэгцээт боловсролын хамран сургалтын хувь	2020	Тусгай хэрэгцээт боловсролын хамран сургалт 40 хувь	2021	0.6 хувь нэмэгдүүлнэ	2021-2022 оны хичээлийн жилийн жилд ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй 105 хүүхэд, үүнээс эмэгтэй 51, СӨБ-д хөгжлийн бэрхшээлтэй 38 хүүхэд, насан туршийн боловсролд 38 хүүхэд, ХБХЗХТөөвөр 20 хүүхэд нийт 201 хүүхэд буюу 44% нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
14	2.3	Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ.	0	0	СӨБ-ын хамран сургалт,	2020	СӨБ-ын хамран сургалт 94.6 хувь	2021	СӨБ-ын хамран сургалт 94.6 хувь	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 86.5 хувьд хүрсэн. 4 сургууль 1 цэцэрлэгийг ашиглалтад оруулж, 2100 хүүхдийн суралцах орчинг бүрдүүлсэн. "Цэцэрлэгийн менежмент манлайлал, технологи" сэдэвт 48 цагийн и-сургалтад цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч 50, "Мэргэжлийн хөгжлийн бүлэг"-т 65, СӨБ-ын Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга зүй-135, Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр ба үнэлгээ сургалтад 54, Эко цэцэрлэг түүнд тавигдах шаардлага хэрэгжүүлэх арга зам 240, дэлхийн том хичээл багшийн ур чадвар -89,Цэцэрлэгийн хамгаалал хүмүүжлийн эерэг арга багш туслах багш 278 багшийг тус тус чадваржуулах сургалтад хамруулсан.	70
15	2.4	Сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламжийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, барилгын стандарт, норм нормативийг мөрдүүлж, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ.	18.529.1	18.529.1	Ашиглалтад орсон барилга байгууламж, их засварын гүйцэтгэл	2020	ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн 9 барилгыг ашиглалтад оруулах	2021	9 барилга ашиглалтад оруулах	Улсын төсвийн хөрөнгөөр Баянхонгор сумын ЕБС-ийн "Номгон" ахлах сургуулийн хичээлийн байрны 440 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилга ашиглалтад орж 800 гаруй хүүхдийн сурах орчин бүрдэж, сургуулийн ээлжийн коэффициент 0.3 аар буурч сурагчдын суралцах, багш нарын ажиллах таатай орчин бүрдлээ. Шинэ суурьшлын бүсийн 640 хүүхдийн суудалтай хичээлийн барилгыг улсын комисс хүлээн авсан, тус сургуулийн дэргэдэх цэцэрлэгийн бүлэг үйл ажиллагаагаа цахимгаар эхэлсэн, Баян-Овоо сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга ашиглалтад орж 50 хүүхдийн сурах орчин цэцэрлэгийн багш, ажилчдын ажиллах нөхцөл сайжирсан. Заг, Баянцагаан, Гурванбулаг сум, Баянхонгор сумын Шаргалжуут тосгоны сургуулийн хичээлийн байрны барилгын ажил 30-60 хувийн гүйцэтгэлтэй байна.	31
16	2.5	Сургуулийн дотуур байр, гал тогоо, спорт болон урлагийн заалны хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль бүрт "Үдийн хоол" олгох боломжийг бүрдүүлнэ.			Гал тогооны тоног төхөөрөмжийн хангалт, үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилт	2020	11 сургууль стандарт хоолны заалтай, 14 сургууль дотуур байрны гал тогоогоо ашиглаж байна.	2021	Стандарт хоолны заалын тоог нэмэгдүүлэх	ЕБС-ийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 207 дугаар тогтоолоор баталсан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны хичээлийн жилээс эхлэн аймгийн хэмжээнд 1-5 дугаар ангийн 9849 хүүхдийн үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна Номундалай, Номгон, Эрдэнэмандал, сургууль цэцэрлэгийн "Баян-Ойт" цогцолбор, Өлзийт, Жинст, Баянлиг, Баянговь, Бууцагаан, Баянбулаг, Баян-овоо зэрэг 11 сургууль хичээлийн байрандаа стандартын хоолны заалтай бусад 14 сургууль нь стандартын хоолны заалгүй байна. Баянхонгор сумын Соогоо сейкео, "Эрдэм" ЕБ-ын ахлах сургууль, Хүрээмарал сумын сургуулиудын гал тогооны тоног төхөөрөмжийг төсвөөс шийдэж бусад сургуулиудыг төсвийн хэмнэлтээс гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилсэн.	70
17	2.6	Насан туршийн боловсролын хүртээмийг нэмэгдүүлж, цахим сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ.	15	3	Сургалтад хамрагдсан хүний тоо	2020	12500	2021	10000	Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд боловсрол нөхөн олгох сургалтад 464 суралцагч суралцсанаас суурь боловсролоос 1, бүрэн дунд боловсролоос 1 суралцагч ЕБС-д шилжин суралцсан бөгөөд бага боловсролыг 5, суурь боловсролыг 110, бүрэн дунд боловсролыг 82 суралцагч, дүйцсэн хөтөлбөрөөр 40, хөгжлийн бэрхшээлтэй 28 суралцагч суралцаж дараагийн шатны сургалтад хамрагдах боломж бүрдсэн. Бичиг үсгийн сургалтад 113 иргэн хамрагдсанаас анхан шатанд 51, дунд шатанд 43, гүнзгий шатанд 8, дараах шатанд 11 иргэн суралцаж бичиг үсгийн чадвартай болсон. Давхардсан тоогоор 12 чиглэлийн хүрээнд 25193 иргэдэд 738 төрлийн 947 сургалт явуулж үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 471 хамрагдсан байна. Гэр бүлийн боловсрол чиглэлээр 2487 иргэдэд 72 төрлийн 115 сургалт явуулсан.Тус чиглэлийн хүрээнд 52 постер, 57 шторк, цахим хичээл 62, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан ажилласан байдал152 байна. Гоо зүйн мэдрэмжийн боловсрол чиглэлээр 3220 иргэдэд 49 төрлийн 81 сургалт явуулсан Тус чиглэлийн хүрээнд постер 79, шторк 71, цахим хичээл 80 -ыг бэлтгэж олон нийтийн сүлжээгээр түгээж ажилласан. Үүний үр дүнд иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлсэн.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
18	2.7	Орон нутагт эрэлт хэрэгцээтэй мэргэжлийн боловсон хүчнийг үе шаттайгаар сургаж, Политехникийн коллежид төмөр замын чиглэлээр мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, ажлын байраар хангана.	0	0	0	0	0	0	0	0	0
19	2.8	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангах, сургууль орчны нэвтрэлт бүртгэлийн системийг шинээр нэвтрүүлнэ.	0	0	Сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангасан байдал	0	0	0	Тоног төхөөрөмжийн хангалт багш нарын бэлгэсэн байдал	ЕБС-ийн 426 багш Google apps хэрэгслүүд, powtoon, socrative, skype, voov, worldwide, arduino, plickers, bandicam, camtasia, зэрэг сургалтын программуудыг ашиглаж сургалт зохион байгуулах чадвартай болсон. Мөн econtent.mn, xreading, lmath.mn зэрэг сайтуудыг сургалтад ашиглаж байна. Багш нарт сургалтын үйл ажиллагааг цахимаар явуулах сургалтыг 2 үе шаттай зохион байгуулж нийт 122 багш хамрагдлаа. Сургалтаар багш нар хэрхэн classroom үүсгэж, google meet-тэй холбох аргачлалыг танилцуулж, сургалтын явцад мэдсэн зүйлээ ашиглаж анги үүсгэх түүнийгээ баталгаажуулж даалгавар илгээх үйл ажиллагааг хийж гүйцэтгэх чадвар эзэмшлээ. Мөн “Цахим сурах бичгийн онол арга зүй” сэдэвт сургалт явуулж “Цахим сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх онол зүй сургалтын агуулга модулийг боловсруулан classroom үүсгэж багш нарыг нэгтгэн, googlemeeting ашиглан 91 багшийг хамруулан цахимаар сургалт явуулах бэлтгэлийг хангасан.	70
20	2.2	Зорилт 2.2 Аймгийн хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.	Салбарын төсвөөс	Салбарын төсвөөс	Хүн амын дундаж наслалтын нэмэгдсэн үзүүлэлт Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү	2020	Аймгийн хэмжээнд хүн амын дундаж наслалт 2020 оны байдлаар 70.25 байна. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.6, эмэгтэйчүүдийнх 72.9 байгаа нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт	2021	Эрэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүг 2022 онд 0.2-оор бууруулна.	Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд амьдралын зөв зан үйл, дадлыг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, халдварын болон халдварт бус өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хүн амын дундаж наслалт 2020 оны байдлаар 70.25 байна. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.6, эмэгтэйчүүдийнх 72.9 байгаа нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс 5.3- оор бага байна. Дэлхийн жишгээр дундаж наслалтыг 1 жилийн хугацаанд нэмэгдүүлэх, хүйс хоорондын зөрүүг арилгах боломж хомс байдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүг 2022 онд 0.2-оор, 2025 онд 1.5 болтол бууруулах зорилт тавин ажиллаж байна.	100
21	2.2.1	Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	1.5 тэрбум	1.8 тэрбум	Орон нутагт нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээнд хамрагдах боломж нөхцлийг бүрдүүлсэн байна.	2020	70 хувь	2021	Оношлогоо үйлчилгээний чадамжийг 90 түүнээс дээш хувьд хүргэх	Нэгдсэн эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг сайжруулж, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар молекул биологийн аппаратаар хангаж, мэргэжлийн эмч, лаборантыг ХӨСҮТ-д сургаж, 5 сарын 23-наас үйл ажиллагааг эхлүүлсэн. Шинжилгээ хийх явцад гадаад ба дотоод хяналтад бүрэн хамрагдаж, ХӨСҮТ-ийн вирус судлалын төв лабораторид 50 сорьц, зэрэг хяналтын шинжилгээг хийлгэхэд шинжилгээний хариу тохирч, хангалттай дүгнэгдэн батламж авч, цаашид шинжилгээг үргэлжлүүлэн хийх зөвшөөрөл авсан. Мөн Нэгдсэн эмнэлэг нь телемедициний зориулалтын тоног төхөөрөмж ашиглан дээд шатлалын байгууллагуудын эмч нараас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, арьсны үзлэг оношлогоо хийдэг Дерма программаар иргэдийг зайнаас оношлох үйл ажиллагаа явагдаж байна. ЭМЯ-ны 1 тэрбум 780 сая төгрөгийн хөрөнгөөр Компьютер томографи, 94.0 сая төгрөгийн 3 ширхэг унтуулгын аппарат нийлүүлэгдэж, эмчлүүлэгчдийн чирэгдлийг багасган, оношлогоо эмчилгээний чадамжийг бүрэн сайжруулсан.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
22	2.2.2	Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ	20.0 сая	0	Эрэгтэйчүүдэд тусламж үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлэн, чанар хүртээмжийг сайжруулсан байна.	2020	Аймгийн эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.6, эмэгтэйчүүдийнх 72.9 байгаа нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс 3.2- оор бага байна. /2020/ Эрэгтэйчүүдийн кабинет, мэргэжлийн эмч	2021	Арга хэмжээний хэрэгжилтийг 80 түүнээс дээш хувьтай хэрэгжүүлнэ.	Аймгийн Засаг даргын 2021 оны А/461 дүгээр захирамжаар “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр” боловсруулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын орлогч Г.Энхбаяраар ахлуулан 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Уг ажлын хэсэг хөтөлбөрийн хүрээнд салбар бүрийн саналыг авч, олон нийтийн дунд цахимаар санал асуулга явуулсан. 2021 онд эрэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчийг бэлтгэсэн. Мөн аймгийн хэмжээнд 2022-2024 онд хэрэгжүүлэх “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих” арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, 2022 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	70
23	2.2.3	Иргэдийн дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулж, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулж, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	Салбарын төсвөөс	Салбарын төсвөөс	Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулсан байна. Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна.	2020	Эрт илрүүлгүүдийн дундаж үзүүлэлт 82 хувьтай. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дундаж 86 хувьтай.	2021	Арга хэмжээний хэрэгжилтийг 80 түүнээс дээш хувьтай хэрэгжүүлнэ.	Аймгийн хэмжээнд артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 65.6 хувь /2020 онд 82.7% буюу 17.1 буурсан/, чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэг 96.5 хувь /2020 онд 78.7%/ байгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17.8 хувь өссөн үзүүлэлттэй байна. Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгт нийт 29050 хүн хамрагдаж, үүнээс давтан үзлэгийн 398 хүнээс 211 буюу 53.1 хувьд, чихрийн шижингийн эрт илрүүлэгт нийт 23247 хүн хамрагдаж давтан үзлэгт 74 хүн хамрагдсанаас 15 буюу 20.2 хувьд нь чихрийн шижин оношлогдсон. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 4993 зорилтот насны эмэгтэй хамрагдахаас 2997 эмэгтэй хамрагдаж, 60.2 хувьтай байна. Үүнээс шинжилгээний дүн эерэг гарсан 20, хавдрын урьдал гарсан 10, умайн хүзүүний хорт хавдар 4 илрүүлэн эмчийн хяналтад авсан. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 2986 эмэгтэй хамрагдаж, хөхний эмнэлзүйгээр эерэг өөрчлөлттэй гарсан 10 хүнийг III шатлалын эмнэлэг рүү шилжүүлж, хөхний хорт хавдар илрээгүй. Элэг бүтэн дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 89300 иргэнээс илрүүлэг үзлэгт 95-96.0 хувьтай хамрагдаж, хөтөлбөрийн хүрээнд элэгний С вирустэй 4000, В вирустэй 2700 иргэнийг илрүүлэн, элэгний С вирустэй иргэнийг 80-90.0 хувь эмчилж эрүүлжүүлэн эмчийн хяналтад авч ажиллаж байна. “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах хөтөлбөр”-ийн хүрээнд 5 зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэн, хэрэгжилт 91	100
24	2.2.4	Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж эх, хүүхдийн эндэгдэл, үр хөндөлтийг бууруулах зорилгоор “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн зардлаас	Хөтөлбөрийн зардлаас	Эх хүүхдийн эндэгдлийг бууруулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байна.	2020	Хөтөлбөрийн дундаж хэрэгжилт хувьтай 90	2021	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 80 түүнээс дээш хувьтай хэрэгжүүлнэ.	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг 2021 онд 5 зорилтын хүрээнд 12 ажил зохион байгуулан, 57.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн батлуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 85 хувьтай байна. Жирэмсний хяналтад шинээр 1610 эмэгтэй орсноос эхний 3 сартай 1449 эх хяналтад орж, 90.0 хувьтайгаар хэрэгжиж байна. Коронавирусын халдварын хүндрэлээр 1 эхийн эндэгдэл бүртгэгдсэн. Хяналтанд орсон эмэгтэйчүүдийг БЗДХ, элэгний В,С вирусын халдварыг илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулсан. Одоогоор төрөлхийн тэмбүү өвчин бүртгэгдээгүй. Эхний 11 сарын байдлаар эхийн ноцтой хүндрэлийн 7 тохиолдол бүртгэгдсэн. Аймгийн төвд 6, хөдөө орон нутагт 1 тохиолдол бүртгэгдэж, Нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, эрчимт эмчилгээний их эмч нар багаар ажиллаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэснээр 7 эхийн амь насыг аварсан байна.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
25	2.2.5	Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг багасгана.			Анхан шатлалд тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулсан байна.	2020	Арга хэмжээний хэрэгжилт хувьтай	70	2021	Арга хэмжээний хэрэгжилтийг 80 түүнээс дээш хувьд хүргэх	ДЭМБ-ын санхүүжилтээр Бөмбөгөр, Баянцагаан сумын эрүүл мэндийн төв, 2021 оны 6 дугаар сард ЭМЯ-ны 244.6 сая төгрөгийн санхүүжилтээр 16 сум, 4 ерхийн ЭМТөв мобайл технологийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдаж, Мобайл технологийн тусламжтайгаар гэрээр, отор нүүдлээр, алслагдсан багийн иргэдэд нарийн мэргэжлийн оношлогоо, үзлэг шинжилгээг зохион байгуулах боломж бүрдэж, анхан шатны эмнэлгүүд 100 хувь уг технологийг нэвтрүүлэн тусламж үйлчилгээндээ ашиглаж байна.	100
26	2.2.6	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	9 тэрбум	11.4 тэрбум	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж, өр авлагагүй ажилласан байна.	2020	Өр авлагагүй, үр ашигтай ажилласан.		2021	Гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнгээр	Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь бүтэц үйл ажиллагааны стандартад заасан үндсэн тусламж үйлчилгээ болон ковидын тусламж үйлчилгээг үр дүнтэй үзүүлж, 2021 онд гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас 11.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, 3 тэрбум төгрөгийн авлагатай, үр ашигтай өргүй ажилласан.	100
27	2.2.7	Эрүүл мэндийн ажилтны үр чадварыг сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	Салбарын үйл ажиллагааны зардлаас	Салбарын үйл ажиллагааны зардлаас	Эмч мэргэжилтний үр чадварыг дээшлүүлэн, шаардлагатай мэргэжлээр сургаж, ёс зүйн алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлсэн байна.	2020	Зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт хувьтай.	85	2021	Зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувиар	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эрүүл мэндийн байгууллагууд дотоодын нөөц боломжиндоо тулгуурлан ажлын байрны сургалтыг зохион байгуулж, эмч сувилагч мэргэжилтний мэдлэг үр чадварыг дээшлүүлж байна. Эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараах сургалтад шаардлагатай мэргэжлийн чиглэлээр 2021-2022 онд үндсэн мэргэжлээр нүүр амны согог засал судлал, сэтгэц судлал, хүүхэд судлал, сумдын эрүүл мэндийн төвд эх барих эмэгтэйчүүд судлал, мэдрэл судлал, дотрын анагаах судлал, ЗӨСТ-д зоонозын өвчин судлал чиглэлээр нийт 11 их эмч, төрөлжсөн мэргэшлийн сургалтаар дотоод шүүрэл, настан судлал, хүүхдийн уушги судлал, биостатистик тархвар зүйн чиглэлээр нийт 6 их эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэн, дархлаажуулалтын сувилахуй, нүүр ам, хүүхдийн сувилахуй, клиник биохими судлалын техникчийн сургалт, ариутгагчийн сургалт, эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтны сургалтад 12 сувилагч, тусгай мэргэжилтэн тус тус улсын төсвийн санхүүжилтээр суралцуулсан. "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, төлөвшил, хариуцлага" сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн улсын анхдугаар цахим хурал 2021 оны 2 дугаар сарын 26-нд зохион байгуулагдаж, тус хурлаас ЭМЯ, БШУЯ хамтран Эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнүүдэд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн төлөвшил, үүрэг хариуцлагыг сайжруулах асуудлуудыг хөндсөн зөвлөмж гаргаж, уг зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Нэгдсэн эмнэлэг "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, ёс зүйтэй хамт олон больё" аяныг өрнүүлж шилдэгүүдээ шалгаруулан дүгнэж, олон нийтэд сурталчилан үйлчилгээг сайжруулж ажилласан.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
28	2.2.8	Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэнэ.	12.5 тэрбум	4.1 тэрбум	Барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлээр	2020	Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь	2021	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	Нэгдсэн эмнэлгийн 9.4 тэрбум төгрөгийн өртөгтэй амбулаторын барилга одоогийн байдлаар суурь бүрэн хийгдэж, 1 болон 2 дугаар давхарын каркас угсралтын ажил явагдаж, 30.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүрээмарал сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Зураан Даваа ХХК" шалгарч гүйцэтгэл 70.0 хувьтай, одоогийн байдлаар барилгын гадна, дотор заслын ажил хийгдэж байна. Эрдэнэцогт сумын 1.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий жишиг эрүүл мэндийн төвийн барилгын гүйцэтгэгчээр "Рино Инженеринг ХХК" шалгарч, одоогийн байдлаар эмнэлгийн 2 давхар болон эмчийн байр, моргийн барилгын өрлөг хийгдэж, дулааны шугам татагдаж, гүйцэтгэл 50.0 хувьтай байна. Оточмандал өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын засвар нийт 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэгчээр "Гурван тахилгат ХХК" шалгаран өргөтгөлийн ажлыг гүйцэтгэж, одоогоор 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Эрдэнэцогт, Хүрээмарал сумын ЭМТ-ийн барилгууд ашиглалтад орсноор эмч, эмнэлгийн ажилчдын тав тухтай стандартын шаардлагад нийцсэн орчин нөхцөлд үйл ажиллагаа явуулах боломж бүрдэж, тус сумдын 6241 хүн амын ээлтэй орчин нөхцөлд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ авах нөхцөл бүрдэнэ. Нэгдсэн эмнэлгийн амбулаторын барилгыг ашиглалтад хүлээн авснаар тав тухтай орчинд аймгийн 89000 гаруй иргэдэд II дугаар шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх, төрөлжсөн нарийн мэргэжлийн оношлогоо эмчилгээнд хамрагдах боломж нөхцлөөр хангагдана.	100
29	2.2.9	Эм, эмнэлэгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, сумдын эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааг сайжруулж, үнийн нэгдсэн бодлогыг бий болгоно.	Салбарын үйл ажиллагааны зардлаас	Салбарын үйл ажиллагааны зардлаас	Аймгийн хэмжээнд эмийн сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.	2020	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь 85	2021	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн хувиар	Эмийн эмчилгээг зохицуулах хорооны 2019 оны А/414 тоот тушаалын дагуу "Антибиотикийн дэд хороо"-ны ажлыг төлөвлөн антибиотикийн зохистой хэрэглээний судалгааг гаргаж, "Ухаалаг хэрэглээ-соёлтой үйлчилгээ" аяны хугацаанд аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 1-р зэрэглэлийн 10, 2-р зэрэглэлийн 13 эмийн сангийн дунд гарын авлага, зөвлөмжүүдийг хүргэснээр ижил үйлчилгээ, найрлагатай эмийн худалдан авалт буурсан байна. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, антибиотикийн нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх аяны хүрээнд ажлын төлөвлөгөө гарган ажиллаж, тасаг нэгжүүдийн нийт 325 хэвтэн эмчлүүлэгч болон үйлчлүүлэгчдэд сургалт явуулж, антибиотикийн талаарх мэдээлэл өгч, антибиотикийн хэрэглээний судалгааг улирал бүр хийсэн. Эмнэлэгт "Жорын стандарт MNS:5376:2014" стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, амбулаторын жор бичилтэнд хяналт тавьж, эмч нарыг стандартын жорын маягаар хангаж, хяналт тавин ажиллалаа. Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар 20 сумын эмийн санд тусгай зөвшөөрөл олгож, ЭМГ, сумын ИТХ, сумын ЭМТ, эмийн сангуудтай дөрвөлсөн гэрээ байгуулан, сумдын эмийн сангуудын үйл ажиллагааг сайжруулж, үнийн нэгдсэн бодлогыг бий болгож, хяналт тавин ажиллаж байна.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
30	2.2.10	Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулах (Үзлэгийн цаг захиалга, эмчийн үзлэг, өвчтөний цахим карт, лабораторийн хариуг цахимаар авах үйл ажиллагаа)	Төсөв шаардлагагүй	Төсөв шаардлагагүй	Эмнэлгийн үйлчилгээг цахимд системтэй шилжүүлсэн байна.	2020	Эмнэлгийн лабораторын үйл ажиллагаа, зарим онцлог тасаг нэгжийн истори, иргэдийн үзлэгийн захиалах үйлчилгээ нэвтрээгүй байсан.	2021	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн хувиар	Нэгдсэн эмнэлэгт 37 ширхэг хурууны хээ уншигчийг 4625,000 төгрөгөөр худалдан авч, жор бичих нөхцлийг цахимжуулан, үйл ажиллагаандаа ашиглаж байна.Эмчилгээ, оношлогооны чанар, хүртээмж, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах, эмч эмнэлгийн мэргэжилтний анагаах ухааны мэдлэгийг нэмэгдүүлж, тасралтгүй суралцах боломж олгохын тулд UpToDate олон улсын эмнэлзүйн цахим платформыг нэвтрүүлсэн. Нэгдсэн эмнэлгийн 68 эмч, сумын 12 эмчийн компьютерт уг программыг суулгаж, үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн. Лабораторийн шинжилгээний хариу болон сувилгааны түүх цахимд бүрэн шилжсэн. Одоогоор өвчтөний түүх цахим хэлбэрт шилжээгүй байна. Нэгдсэн эмнэлгийн дотор, мэдрэл, мэс засал, хүүхэд, лабораторын тасгийн өвчний түүх болон сувилгааны түүх цахимд шилжсэн. Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үзлэг, цаг захиалга цахимжиж, иргэд үзлэгийн цагаа цахимаар авах боломж нөхцөл бүрдсэн. Нэгдсэн эмнэлгийн амбулаторын үзлэгийн цаг ЭМХТ-ийн Мэдээллийн нэгдсэн системд холбогдон 1800-0119 дугаараас иргэд үзлэгийн дарааллыг захиалаж эхлэснээр үйлчлүүлэгчдийн санал, гомдол буурсан.	100
31	2.3.	Зорилт 2.3 Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжил, хамгааллыг сайжруулна.	500.0 мян.төг	500.0 мян.төг	Гэр бүлрүү чиглэсэн арга хэмжээний тоо	2020	Гэр бүлд чиглэсэн 4 төрлийн арга хэмжээ зохион байгуулж 38 гэр бүлд хүрч ажилласан.	2021	Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд "Ханьсахын заяа", "Баярлалаа" нэвтрүүлэг, "Манай гэр бүлийн хоолны жор" контент, "Ханьдаа бичих захидал" цахим уралдаануудыг зохион байгуулсан. Тухайн арга хэмжээнд хамрагдсан гэр бүлийн тоо 96, хандалтын тоо 2415 байна.	100
32	2.3.1	Гэр бүлийн боловсролыг бүх насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно.	0	0	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2020	Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг 384 хүнд зохион байгуулсан.	2021	Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг 2000-аас доошгүй хүнд зохион байгуулсан байна.	Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг ГБХЗХГ-аас цахимаар 4 удаа, эвлэрүүлэн зуучлах үйлчилгээнд хамрагдаж буй гэр бүлүүдэд 1 удаа, төрийн 8 байгууллагад 8 удаа, иргэдийн хүсэлтийн дагуу 9 удаа нийт 21 удаа зохион байгуулж 564 гэр бүл /1128 хүн/-д, сумдын нийгмийн бодлогын ажилтнууд 2568 хүнд нийт 3696 хүнд сургалтыг зохион байгуулсан.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
33	2.3.2	Хуримын ордныг ашиглалтад оруулж, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулна.	0	0	Үйлчилгээ үзүүлсэн залуучуудын тоо	2020	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 83 дугаар тогтоолоор зөвлөгөө өгөх төв байгуулах шийдвэр гарсан. Гэр бүлийн зөвлөгч 9 дүгээр сараас ажиллаж гэр бүлийн бүтэц, салалтад дүн шинжилгээ хийж, 35 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн. Номгон, Баян-Ойт, 5 дугаар цэцэрлэгт залуу аав, ээж, хөвгүүдэд зориулсан зорилтот хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн.	2021	Гэр бүлийн боловсролыг өсвөр үе, залуучууд бүх насны эрэгтэй, эмэгтэй хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно. 4-5 төрлийн үйлчилгээг нэг доороос үзүүлэх боломж бүрдэж зорилтот 3-аас дээш хөтөлбөр хэрэгжүүлж мэргэжлийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэнэ.	Хуримын ордон ашиглалтад орох хугацаа хөрөнгө санхүүгийн асуудал шийдэгдэхгүй он дамжин 2022 оны 03 дугаар сард ашиглалтад орох болсон. Барилгын гүйцэтгэл 70%-тай байна. ГБХЗХГ-ын хамгааллын мэргэжилтэн, гэр бүлийн мэргэжилтэн, сэтгэлзүйчээр дамжуулан 89 гэр бүлийн 175 гишүүдэд, "Жаргалтай амьдрал" төвөөр үйлчлүүлсэн иргэдийн гэр бүлд хосын болон ганцаарчилсан зөвлөгөөг 24 гэр бүлд өгсөн. Гэр бүлийн боловсрол, гэр бүлийн харилцаа сэдэвт сургалтыг 12 байгууллагын 978 төрийн албан хаагчдад зохион байгуулсан.	100
34	2.3.3	Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	7.0 сая.төг	7.0 сая.төг	Үйлчилгээ үзүүлсэн залуучуудын тоогоор	2020	Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд 749 залууд хүрч ажилласан.	2021	Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн биелэлт 80%-иас доошгүй байна.	Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 5.4.8, 5.5.4, 5.5.6, 5.3.17, заалтын хүрээнд Залуучуудын хөгжлийн төв нь 18 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 9568 /35.2%/ залуучуудыг хамруулсан. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг 2 удаа хуралдуулсан.	100
35	2.3.4	Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлж, сум бүрт хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана.	0	0	Зусланд амарсан хүүхдийн тоо, хөгжлийн хөтөлбөрийн тоогоор	2020	Зусланд төрлийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж 95 хүүхэд амарсан байна.	2021	Зусланг орчин үеийн жишигт нийцүүлэн тохижуулсан байна.	Ковид-19" коронавируст халдвар дэгдэж улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан хүүхдийн "Өвгөнжаргалант" зуслан болон хөдөлмөр зуслан ажиллаагүй болно.	0
36	2.3.5	Хүүхдийн эрхийг дээдлэн "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийг хэрэгжүүлж, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтад өртсөн иргэнийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлнэ.	0	0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2020	85%	2021	90% дээш	Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч баг тайлангийн хурал 1 удаа, стратеги төлөвлөгөө боловсруулах чиглэлээр 1 удаа нийт 2 удаа хурал зохион байгуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээ зохион байгуулж 1268 хүнийг хамуулсан. Хүүхдэд ээлтэй орон нутаг стратегийг боловсруулж байна.	70

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
37	2.3.6	Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна.	3.0 сая.төг	3.0 сая.төг	Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлсэнээр	2020	Угийн бичгийн гарын авлага боловсруулсан Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 2021 оны	2021	Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог 15-аас доошгүй хувиар	ГБХЗХГ, Ураг удам уламжлалын "Хонгор" холбоо хамтран угийн бичиг хөтлөх дэвтэрийн эхийг бэлтгэн хэвлүүлж 4000 ширхэгийг өрхүүдэд хүргүүлсэн. Угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх зорилгоор 26 удаа 2073 иргэнд сургалт зохион байгуулж гарын авлага тараасан. Үүний үр дүнд угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 6.1%-иар өссөн байна.	100
38	2.3.7	Зорилт 2.4. Орон нутгийн хөгжилд инновац шингэсэн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.								хэрэгжээгүй	0
39	2.4	Зорилт 2.4. Орон нутгийн хөгжилд инновац шингэсэн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.								хэрэгжээгүй	0
40	2.4.1	Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан "Судалгааны баг" байгуулж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.								хэрэгжээгүй	0
41	2.4.2	Эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.								хэрэгжээгүй	0

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
42	2.5	Зорилт 2.5. Иргэдэд ээлтэй, аюулгүй амьдрах, баталгаат орчныг бий болгоно.	2 тэрбум 190 сая.төгрөг	70%	Шинээр баригдсан авто зам болон, Засвар хийсэн авто замын хэмжээгээр. Мөн нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн тоогоор	2020	Байдрагийн гүүр-Говь-Алтай чиглэлийн 126.7 км болон аймгийн төвийн 2,7 км хатуу хучилтай авто зам тус бүрийн барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн. Галуут сумын Өлзийт, Цагаан туруутын гол тус бүрийн төмөр бетон гүүрийн ажлыг бүрэн гүйцэтгэсэн..	2021	Баянхонгор аймгийн төвд 1.2км хатуу хучилтай замын Улсын чанартай авто замууд болон орон нутгийн чанартай замуудын уулзваруудад тэмдэг, хаягжуулалт, хэвтээ тэмдэг, тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэнэ. Аймгийн төвийн 15 км хатуу хучилтай авто замын нөхөөс, 60 ширхэг тэмдэг	Баянхонгор аймгийн төвд 1.2км замын барилгын ажил, Баянхонгор-Говь-Алтай чиглэлийн А0303, Баянхонгор- Өвөрхангай чиглэлийн А0302 чиглэлийн улсын чанартай авто замууд болон орон нутгийн чанартай замуудын уулзваруудад тэмдэг, хаягжуулалт, хэвтээ тэмдэг, тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэсэнээр иргэдийн ая тухтай зорчих нөхцөл бүрдэж байна. Аймгийн төвийн 15 км хатуу хучилтай авто замын нөхөөс, 60 ширхэг тэмдэг, тэмдэглэгээг шинэчлэх ажлыг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж байна. Баянхонгор сум нь 2021 онд нийтийн тээврийн үйлчилгээний зориулалттай 4 чиглэлд 8 Эко автобус явуулж эхэлсэн нь аймгийн төвийн иргэдийн ая тухтай зорчих боломжийг бүрдүүлж байна.	70
91	6.1.2	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөнө.		-	Өргөтгөсөн тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээгээр	2020	Орон нутгийн тусгай хамгаалалттай 2653229,5 га талбай байна.	2021	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөнө.	"Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь" төслийн хүрээнд Баацагаан сумын Бөөнцагаан нуурыг Байгалийн цогцолборт газрын улсын тусгай хамгаалалтад авах судалгааг хийж, холбогдох бичиг баримтыг боловсруулан тус сумын багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын захирамжаар Улсын газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөг 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталсан. Тус төлөвлөгөөнд Баянхонгор аймгийн Жинст, Баацагаан сумын Нарийн харын нурууны Үнхэлцэг уул, Өлзийт сумын Улаан чулуут уул, Баацагаан сумын Бөөнцагаан нуур, Баацагаан, Баянцагаан сумын Их аргалант уул, Эрдэнэцогт сумын Шаргалжуутын рашаан орчмын газар, Шинэжинст, Баян-Өндөр сумын Эдрэнгийн нуруу, Галуут сум Олгой нуур-Товцог хайрхан, Шинэжинст, Баянлиг сум, Баянговь сумын Баянбулгийн тал зэрэг газрыг Байгалийн нөөц газрын ангилалаар, Галуут сум Хавцал, Баян-Овоо, Өлзийт сумын Цахир уулыг Дурсгалт газрын ангилалаар Богд сумын Их Богд уулын өргөтгөл Орог нуур, Шинэжинст, Баян-Өндөр сумын Номингийн говь-Ногоон цавын хоолой Дархан цаазат газрын ангилалаар тусгай хамгаалалтад авахаар төлөвлөгөөнд оруулсан.	31

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
92	6.1.3	Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эхүүдийг судалж хамгаалах, урсацыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллана.			Тарьсан мод, суулгацын тоо, усны бүрэлдэх эхийг тусгай хамгаалалтад авсан тоогоор	2020	-	2021	Усны нөөц нь тогтоогдсон газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, Түйн голын урсацыг нэмэгдүүлсэн байна.	Бөмбөгөр сумын газрын доорх усны нөөц нь тогтоогдсон ордыг гадаад тэжээгдлийн мужийн хилийн заагаар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 1/24 тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Мөн Баянговь сумын газрын доорх усны нөөц нь тогтоогдсон ордыг гадаад, дотоод тэжээгдлийн мужийн хилийн заагаар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 14 тоот тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Түй, Байдрагийн голын урсац бүрэлдэх эх нийт 592 мянган га талбайгаас улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авагдсан 300 мянган га орчим талбайг хасаж зураглал хийгдэж байна.	31
93	6.1.4	Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээнэ.		Улсын төсөв /100.0/ БОНС АХ /71.1/ Төсөл /82.5/	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээгээр			2021	Газрын доройтол цөлжилтөөс сэргийлж эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээнэ.	Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсэд 50 га талбайд ойн зурвас шинээр бий болгохоор хашаа хамгаалалтын тендерийг зарлан "Би Эйч Энд Ди" ХХК шалгарч гэрээ байгуулсан боловч Ковид-19 цар тахлын улмаас хил гааль хаалттай байгаатай холбоотой бараа, материал хүлээгдэж хашаа хамгаалалтыг хийгээгүй байна. Хашаа хамгаалалт хийгдсэний дараа 5000 ширхэг хайлаас тарихаар хүлээгдэж байна. Амьчуулын шинэ засмал замын ойн зурвас дагуу 1000 метр газрын тор хайс хамгаалалтыг засварлаж, нөхөн тарилт хийж бургас, улиас, хайлаас нийт 2338-ыг тарьсан. Иргэн н.Дэлгэрмаагийн санаачилгаар Оготонотой булгийн баруун талд төгөл байгуулахаар 0,6 га талбай сонгож 9800 ширхэг гоёлын мод тарьж зүлэгжүүлэн усалгааны системтэй болгож хайс хамгаалалт хийсэн. Түйн голын сав дагуу нийт 12138 ш мод тариалж арчилгаа усалгаа Баянхонгор тохижилт үйлчилгээний газар хариуцан ажиллаж байна. Түйн голын Бургасны хойд хэсэгт цагаан бургасны суулгацаар ойжуулалт хийх зорилгоор 300,000 бургасны суулгацыг тарьсан. Тарьсан модны амьдартын хувь нь 70%-тай байна.	31
94	6.1.5	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.			Тарьсан модны тоо, ургалтын хувиар	2020	-	2021	Мод тарина	Монгол Улсын Ерөнхийлөгчийн жил бүрийн 5, 10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн БЯМБА гаригт мод тарих зарлиг, Бүх нийтээр мод тарих өдөр, "Нэг иргэн –Нэг мод" аяны хүрээнд "хашаандаа бүх нийтээр мод тарья" уриатайгаар Баянхонгор сумын 10 багийн айл, өрхийн хашаанд мод тарих арга хэмжээг өрнүүлэн ажилласан. Энэхүү арга хэмжээний хүрээнд "Тарьц, суулгац" мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын мод үржүүлгийн газарт бэлтгэгдэж буй 10 гаруй нэр төрлийн мод бутны тарьц, суулгацын Үзэсгэлэн худалдааг 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Баганат талбайд зохион байгуулан ажилласан. Улаанбаатар хотын "Байгалиа дээдлье" ХХК-тай гэрээ байгуулан 16 төрлийн 15000 мод сөөгийг татан ирж аж ахуйн нэгж байгууллагыг тарьц, суулгацаар хангаж ажиллалаа. Нийт 20 сумын 140 аж ахуйн нэгж байгууллага, 4560 айл өрх, 5319 иргэн, 17 төрлийн 54828 мод тарьж усалгаа арчилгааг хийсэн.	70

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
95	6.1.6	Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлэх, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.			Сургалт, ухуулга мэдээлэл хүргэсэн тоогоор	2020	-	2021	Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлж, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангасан байна.	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах, таслан зогсоох зорилгоор 2021 оны байдлаар Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар давхардсан тоогоор 95 удаагийн хяналт шалгалт хийж 28 зөрчлийг илрүүлж, торгуулийн арга хэмжээг авч ажилласан. Энэ нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулвал байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчил 15,1 хувиар буурсан байна. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл, "Юнител" ХХК, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран Баян-Овоо, Бөмбөгөр сумдын 18 наснаас дээш 1696 иргэнд байгаль орчноо хамгаалах хууль бусаар алт олборлохгүй байх талаар уриалга, анхааруулгыг гаргаж Message хэлбэрээр хүргэж ажилласан. "Байгалиа хамгаалъя" нэгдсэн арга хэмжээний хүрээнд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ түүнтэй холбогдох хууль тогтоомж, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах талаар 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр иргэдэд хуулийн мэдээллийг хүргэж "Номгон телевиз" болон олон нийтийн сүлжээгээр нийтэд сурталчилсан. Аймгийн зах, худалдааны төвүүдээр 2021 оны 04 дүгээр сарын 23, 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд нэн ховор, ховор ан амьтныг агнахыг хориглосон, агнахгүй байх, амьтны гаралтай түүхий эд, эрхтэн бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авахгүй, тээвэрлэхгүй байх талаар 128 иргэнд зөвлөмж хүргэж, иргэдэд хууль бус ангаас өөрсдийгөө хамгаалах, амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ, Амьтны тухай хуулийн 37 дугаар зүйл Амьтны нөөцөл үнрүүлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газар, Рашаан судлалын төв, Ус, цаг уур орчны шинжилгээний хүрээлэн, Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн усны төв, Хими технологийн хүрээлэнгийн хамтарсан багийн 2010 оны судалгаагаар тогтоогдсон 13 рашааны хамгаалалтын бүсийг тогтоож сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Заг сумын Халиут, Жаргалант сумын Цохиот, Уст, Бууцагаан сумын Овоот түрүү, Галуут сумын Өхэг, Өргөөт, Тээлийн рашаануудын эрүүл ахуйн бүс, хориглолтын бүсийг тогтоож, зураглалыг хийсэн.	31
96	6.1.7	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах, усны бохирдол хомсдолыг бууруулж ажиллана.			Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс нь тогтоогдсон усан сан бүхий газрын тоогоор				Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийг тогтоож, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан байна.		31

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
97	6.1.8	Газрын байгалийн тогтоц, нуга, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, Байдраг голыг түшиглэн олон зориулалтаар ашиглах усан сан байгуулна.			Хөв байгуулагдаж, ТЭЗҮ боловсруулснаар			2021	Ус хуримтлуулах хөв байгуулж, Байдрагийн голыг түшиглэн усан сан байгуулах ажлын ТЭЗҮ боловсруулсан байна.	2023-2025 онд хийж хэрэгжүүлнэ.	0
98	6.1.9	Усны нөөц, гидрогеологийн зураглал хийж, усны нөөц баялгийн мэдээллийн сан бүрдүүлэн усны нөөцөд тохирсон хэрэглээг хэвшүүлнэ.		БОНСАХ /7.0/	Усны цахим мэдээллийн сантай болсноор			2021	Усны мэдээллийн цахим сантай болсон байна.	Баянхонгор аймгийн усны тоо бүртгэлийн мэдээлэл, газрын доорх усны нөөц нь тогтоогдсон ордуудын мэдээлэл, хайгуул судалгаагаар нөөцийг нь тогтоож баталгаажуулсан хот суурингийн усан хангамжийн газрын доорх усны ордуудын мэдээлэл, Бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар хайгуул хийгдсэн талбайн мэдээлэл, Баянхонгор сумын мониторингийн цооногийн 2 логгерын дата мэдээллүүдийг тус тус нэгтгэсэн. Баянхонгор аймгийн усны цахим мэдээллийн сангийн програмтай болох ажлын хүрээнд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 7,0 сая төгрөгийн хөрөнгөөр "Бит клаудс систем" ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Гурванбулаг сум нь "Гранд холдинг" ХХК-аар ундны усны эх үүсвэрийн хайгуул судалгааг энэ оны 10 дугаар сард хийлгэсэн бөгөөд худаг гаргах, барилга байгууламжын ажлыг ирэх оны 05 дугаар сард хэрэгжүүлэхээр холбогдох аж ахуй нэгжтэй гэрээ байгуулагдсан. ТИКА-ийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг сумд, КОИСА-ийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр сумд ундны усны эх үүсвэрийн худаг баригдаж ашиглалтад орсон.	70
99	6.1.10	Хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувиар бууруулна.						2021		2022 оноос 20.0 сая мод тарих ажил эхлэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.	0
100	6.1.11	Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.		-	Цаг агаарын урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх мэдээг хүргэснээр	2020 он		2021	Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх эх чадавхийг бэхжүүлнэ.	Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр", тус зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг аймгийн нийт нутаг дэвсгэрийг хамруулж нийт 7 удаа зохион байгуулсан. Аймгийн хангай, тал хээр, говийн нутаг дэвсгэрт үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлнэ. Цаг уурын өртөө, харуулын хэмжилтээр аймгийн нийт нутгаар орсон тунадасны хэмжээ 0.2-35.5мм хур тунадас нэмэгдэж гангийн эрсдэл буурсан. Нийт нутаг дэвсгэрийн 95 хувьд ногооны ургалт урагсан байгаа нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 40 хувиар нэмэгдсэн байна. Цаг агаар муудах бүрт alarm.tsag-agaar.mn сайтад 4 удаа Анхааруулга, Сэрэмжлүүлэг мэдээ оруулсан. Цаг агаарын аюултай үзэгдлийн бүртгэл, судалгааг 1 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл гарган урьдчилан мэдээлэх хэлтэст явуулсан. Нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээ, хоногийн сэрэмжлүүлэг мэдээ, урьдчилан сэргийлэх мэдээний чанар 96,3 хувь, онч 99.4 хувь, аюултай үзэгдэл болон гамшигт үзэгдлийг илрүүлсэн байдал 100 хувьтай байна.	70

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
101	6.1.12	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, хог хаягдлын дахин боловсруулалтын үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.		40	Төлөвлөгөө боловсруулж, батлуулснаар	-	Төлөвлөгөө байхгүй	2021	Хог хаягдлын төлөвлөгөө батлуулсан 2022 оноос баталсан төлөвлөгөө ний дагуу хийж гүйцэтгэнэ.	Орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөөг "Монсерфтф туризм" ХХКомпаниар гүйцэтгүүлж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн 2021 оны 131 дүгээр тогтоолоор батлуулсан.	100
Зорилго 7. Орон нутагт батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.											
102	7.1	Зорилт 7.1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэнэ.			Монгол Улсын "Дайны байдлын тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 24.3, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2019 оны мн/162 дугаар удирдамж, мн/65 дугаар тушаалуудын хэрэгжилтийг хангах.	2020	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулагдаагүй байсан.	2021	Аймгийн "Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах төлөвлөгөө"-г боловсруулж ЗХЖШ-ын даргаар батлуулж, бэлтгэл үүрэгтнүүдийг томилгоожуулж, техник хэрэгслийг даалгаваржуулж, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог шинэчилсэн байх.	Аймгийн "Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах төлөвлөгөө"-г аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулан ЗХЖШ-ын даргаар батлуулж Зэвсэгт хүчний Жанжин штабын дайчилгааны хэлтэст хүлээлгэн өгсөн. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийг томилгоожуулсан. Тайван цагт орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, уламжлалт аюулаас урьдчилан сэргийлэх, уламжлалт бус аюулаас хамгаалах, онц болон дайны байдлын үед орон нутгаа хамгаалах замаар улсыг батлан хамгаалахад дэмжлэг үзүүлэх бэлтгэлийг хангсан байна.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
103	7.1.1	Дайчилгааны төлөвлөлтийг төгөлдөржүүлж, бэлэн байдлыг дээшлүүлнэ.			Монгол Улсын Дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалахын сайдын 2019 оны мн/21 дүгээр тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 600/01, 600/02 дугаар стратегийн удирдамжууд, мн/283, мн/288, мн/420 дугаар дайчилгааны даалгавруудын хэрэжилтийг хангах.	2004	Аймгийн дайчилгааны төлөвлөгөө 2004 оноос хойш шинэчлэгдээгүй байсан. Сумдууд дайчилгааны төлөвлөгөөгүй байсан.	2021	“Зэвсэгт хүчний анги, салбаруудыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө” боловсруулан ЗХЖШ-ын даргаар батлуулж, дайчилгааны даалгавартай команд тус бүрийг хүн, техникээр оногдуулан бүртгэж томилгоожуулан, төлөвлөгөөг хангах.	“Зэвсэгт хүчний анги, салбаруудыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-г боловсруулан ЗХЖШ-ын даргаар батлуулсан. Мөн 20 сумдын дайчилгааны даалгаврыг тогтоон дайчилгааны даалгавартай команд тус бүрт хүн техникийг оногдуулан бүртгэсэн. Аймгийн хэмжээнд дайчилгааны даалгавар биелүүлэх бэлтгэлийг бүрэн хангаж дайчилгааны даалгавартай Зэвсэгт хүчний 339 дүгээр анги, 143,103 дугаар тусгай салбаруудтай тодотгол хийж бэлэн байдлыг хангасан.	100
104	7.1.2	Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, цэргийн бэлтгэл сургалтыг боловсронгуй болгоно.			Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийг суман, бүлгүүдэд томилгоожуулж, сургалтыг зохион байгуулсан байх.	2020	Аймгийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө 2019 онд, сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө 2020 онд тус тус батлагдсан.	2021	Томилгоот бүрэлдэхүүнд цэргийн анхан шатны мэдлэг чадвар эзэмшиж хуулиар хүлээсэн гүйцэтгэх үүрэгт нь дадлагажуулах.	Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай “Дайчилгаа болон Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангахад удирдах албан тушаалтны үүрэг, оролцоо” сэдэвт цэргийн бэлтгэл сургалтыг 10 дугаар сарын 25-27-ний өдрүүдэд Бууцагаан суманд онолын, 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Хүрээмарал суманд онол, дадлагын хэлбэрээр тус тус зохион байгуулж явууллаа.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
105	7.1.3	Хүүхэд залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.			Цэргийн насны болон өсвөр насны иргэдэд Зэвсэгт хүчнийг сурталчилж, эх орон үзэл хүмүүжил олгох.	2020	“Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх.	2021	Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн дагуу тусгай төлөвлөгөөг өөр иргэд олон нийт-хүүхэд залуучуудад чиглэсэн ажлуудыг зохион байгуулж явуулсан байх.	Аймгийн ЕБС-иудын сурагчид, иргэд олон нийтийн дунд Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Эх орон, Монгол цэргээрээ бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Монгол Улсын Зэвсэгт хүчин-100” гар зургийн уралдаан, “Цэрэг-Эх орны сэдэвт дууг хэн сайн дуулах вэ” дууны уралдаан, “Эрхмийн дээд Монгол эр хүн” эсээ бичлэгийн уралдаан, “Эх орныхоо төлөө зүтгэе” фотозургийн уралдаан зэрэг уралдаан, тэмцээнүүдийг цахим хэлбэрээр явуулан тэргүүн байруудыг эзэлсэн сурагчид болон иргэдэд шагнал гардуулах арга хэмжээнүүдийг орон нутагтаа зохион байгуулсан зохион байгуулж явууллаа.	100
106	7.2	Зорилт 7.2. Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоо, бүсчилсэн хил хамгаалалтыг дэмжин, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	3.0 сая/төг	100%	дэмжлэг үзүүлж ажилласан байна.	2020	0	2021	алба хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан байна.	Хилийн болон хилийн боомтын асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомж, Хил хамгаалалтын дүрэм, Хилийн цэргийн командлагчийн “Монгол Улсын хил хамгаалалтыг зохион байгуулах тухай” удирдамж, ангийн захирагчийн Улсын хил хамгаалах тухай тушаалыг үндсэн удирдлага болгон хилийн анги салбарын хүч хэрэгсэл, Баянхонгор, Өмнөговь, Говь–Алтай аймгууд дахь тусгайлсан чиг үүрэг бүхий болон харилцан ажиллагаатай байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, хил хамгаалалтад туслах хүчний гишүүд, иргэдийн оролцоотойгоор хил хамгаалалтыг зохион байгуулж байна. орон нутгийн зүгээс Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилчдийн нийгмийн асуудлыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах зорилгоор Хил хамгаалалтад 1 мотоцикл, 1 принтерээр ханган ажиллалаа.	100
107	7.1.1	Улсын хил хамгаалалт, албаны бэлэн байдлыг дээшлүүлэхэд хамтран ажиллана.	0	0	хилийн асуудлыг шийдвэрлэх захирамж гаргасан байна	2020	0	2021	захирамж гарсан байна.	Улсын хилийн бүсийн өргөн түүний зааг эргэлтийн цэгийг тогтоон тэмдэгжүүлэх ажлын хүрээнд Монгол улсын хил хамгаалах ерөнхий газрын дарга, Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 05/А/290 дүгээр хамтарсан тушаал, захирамжаар хилийн цэсийн өргөнийг шинэчлэн тогтоосон.	100
	7.3	Зорилго 7.3. Иргэдийн аюулгүй байдлын түвшинг нэмэгдүүлнэ									

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
108	7.3.1	Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулна.	477.0 сая/төг	100%	Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн бууралтын тоо Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн бууралтын тоо Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн бууралтынтоо Малын хулгайн гэмт хэргийн бууралтын тоо	2020	Гэмт хэргийн тоо-126 зөрчлийн тоо-1723 Гэмт хэргийн тоо-43 зөрчлийн тоо-155 Гэмт хэргийн тоо -23 Гэмт хэргийн тоо -65	2021	Гэмт хэргийн тоо-125 зөрчлийн тоо-1722 Гэмт хэргийн тоо-42 зөрчлийн тоо-154 Гэмт хэргийн тоо -22 Гэмт хэргийн тоо -64	“Зөв Амьдрал” дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2021 114 дүгээр тогтоолоор батлуулан, аймгийн Засаг даргын 2021 оны А/653 дугаар захирамжаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, 70 хувьтайгаар хэрэгжилтийг ханган ажиллалаа. Эмнэлгийн болон сэтгэц нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг 120 иргэнд үзүүлсэн байна. Үүнээс урьдчилсан үр дүнгээр 75 хувь нь архинаас бүрэн татгалзан цаашид тогтворжуулах эмчилгээнд хамрагдаж, 25 хувь нь дахилт өгч давтан эмчилгээнд хамрагдаад байна. Эхний 11 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 164 бүртгэгдэж 42 нэгжээр өссөн бол, зөрчил 1549 бүртгэгдэж 43 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. Тодорхой үр дүнд хүрсэн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” аймгийн дэд Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны А/71 дүгээр захирамжаар батлан, 100 хувьтайгаар хэрэгжилтийг ханган ажиллалаа. Мөн энэ онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгавар батлан сум, байгууллагуудад хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллаж байна. “Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг угтаж тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын гэр бүлүүдийн дунд “Хайр түгээ” өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. 11 сарын байдлаар Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг 44 бүртгэгдэж, өмнөх мөн үеэс 2 нэгжээр, зөрчил 173 бүртгэгдэж 34 нэгжээр тус тус өссөн байна.	100
109	7.3.1	Иргэдийн Эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	71.5 сая/төг	100%	мэргэжилтэй боловсон хүчний тоо нягтруулсан шүүгээний тоо	2020	183 ширхэг нягтруулсан шүүгээтэй	2021	мэргэжилтэй боловсон хүчин буюу хүний нөөцийн тоо өссөн байна Нягтруулсан шүүгээний тоог нэмэгдүүлсэн байна.	Архив, албан хэрэг хөтөлөлтийн тухай хууль, баримт бичгийн стандарт, албан хэрэг хөтөлөлтийн нийтлэг журмын хүрээнд онлайн сургалтыг 169 байгууллагын 3522 ажилтанд 2 удаа, 35 байгууллагын 522 удирдах болон гүйцэтгэх ажилтнуудад танхимаар сургалт хийж албан хаагчдийн мэдлэгийг дээшлүүлсэн. 3. Орон нутагтаа Архив, бичиг хэргийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг зохион байгуулахаар Аймгийн Засаг дарга Тэнгэр дээд сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан, 20 ажилтан төгсөж, 60 ажилтан эчнээ, өдрийн ангид 8 ажилтныг үнэ төлбөргүй суралцуулж байна.Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зорилгоор 59.8 сая/төг-өөр 70 ширхэг нягтруулсан шүүгээг авч, баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. Төрийн архивын цахим сангийн ажилтнууд 12 сумын мал тооллогын 1990-2018 оны 1544 хадгаламжийн нэгж буюу 362707 хуудас баримтанд цахим хувь үүсгэж, програмд 244159 өгөгдөл, 23 байгууллагын 1980-2000 оны 560 хадгаламжийн нэгж буюу 14317 хуудас баримтанд цахим хувь үүсгэж, програмд 69186 өгөгдөл оруулж хайлтад бэлтгэж ажиллалаа.Төрийн байгууллагын 2018 оны байнга хадгалах 40 байгууллагын 5000 орчим баримтыг эмхлэн цэгцэлж цахим санд шилжүүллээ. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн 651 хадгаламжийн нэгжийн 5160 хуудас баримтыг хүлээн авч цахим санд шилжүүлж, онлайн-аар хайлт хийх боломжийг бүрдүүлж ажилласан	100
110	7.3.3	Албан хэрэг хөтөлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулна	3.0 сая/төг	100%	сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2020	1200	2021	1400	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны А/23 дүгээр захирамжаар баталж, Орон нутгийн төсвөөс 3.0 сая/төг-ийг шийдвэрлэн төлөвлөгөө 91.6 хувьтай хэрэгжсэн байна. Аймгийн хэмжээний сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 50 сэдвийн хүрээнд төлөвлөгөөт 37, төлөвлөгөөт бус 3, захиалгат 20, нийт 70 удаагийн сургалтаар 4000 гаруй төрийн албан хаагч, иргэдэд цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж, 500 гаруй иргэд, төрийн албан хаагчдад хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч хууль тогтоомжийн сурталчилгааг орон нутгийн телевиз, аймгийн www.bayanhongor.gov.mn цахим хуудас, хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар сурталчлан, хялбаршуулсан гарын авлага бэлтгэж иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажиллалаа.	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
111	7.3.4	Дэвшилтэт технологи бүхий гэрэлтүүлэг, камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	71.5 сая/төг	100%	мэргэжилтэй боловсон хүчний тоо нягтруулсан шүүгээний тоо	2020	183 ширхэг нягтруулсан шүүгээтэй	2021	мэргэжилтэй боловсон хүчин буюу хүний нөөцийн тоо өссөн байна нягтруулсан шүүгээний тоог нэмэгдүүлсэн байна.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, баримт бичгийн стандарт, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хүрээнд онлайн сургалтыг 169 байгууллагын 3522 ажилтанд 2 удаа, 35 байгууллагын 522 удирдах болон гүйцэтгэх ажилтнуудад танхимаар сургалт хийж албан хаагчдийн мэдлэгийг дээшлүүлсэн. 3. Орон нутагтаа Архив, бичиг хэргийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг зохион байгуулахаар Аймгийн Засаг дарга Тэнгэр дээд сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан, 20 ажилтан төгсөж, 60 ажилтан эчнээ, өдрийн ангид 8 ажилтныг үнэ төлбөргүй суралцуулж байна. Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зорилгоор 59.8 сая/төг-өөр/ 70 ширхэг нягтруулсан шүүгээг авч, баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. Төрийн архивын цахим сангийн ажилтнууд 12 сумын мал тооллогын 1990-2018 оны 1544 хадгаламжийн нэгж буюу 362707 хуудас баримтанд цахим хувь үүсгэж, програмд 244159 өгөгдөл, 23 байгууллагын 1980-2000 оны 560 хадгаламжийн нэгж буюу 14317 хуудас баримтанд цахим хувь үүсгэж, програмд 69186 өгөгдөл оруулж хайлтад бэлтгэж ажиллалаа. Төрийн байгууллагын 2018 оны байнга хадгалах 40 байгууллагын 5000 орчим баримтыг эмхлэн цэгцэлж цахим санд шилжүүлээ. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн 651 хадгаламжийн нэгжийн 5160 хуудас баримтыг хүлээн авч цахим санд шилжүүлж, онлайнгаар хайлт хийх боломжийг бүрдүүлж ажилласан	100
Зорилго 8. Эдийн засгийн өрсөлдөх чадвар дээшилсэн, хүн амын амьдрах ажиллах таатай нөхцлийг бүрдүүлсэн, дэд бүтэц, ногоон үйлдвэрлэлийг бий болгосон орон нутгийг хөгжүүлнэ.											
112	8.1	Зорилт 8.1. Сум, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.			Дэд бүтцийг сайжруулах ТЭЗҮ боловсруулсан гүйцэтгэлийг сонгон шалгаруулна.	2020	Өлзийт, Галуут сумын хөгжлийг дэмжиж эхэлсэн.	2021	Өлзийт, Галуут сумын хөгжлийг дэмжиж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлсэн байна.	Өлзийт суманд сумын төвийн шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэн 2021 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан. Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Бридж бюлдинг" ХХК гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Ажлын явц 30%-тай байна. Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Бридж бюлдинг" ХХК гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Ажлын явц 30%-тай байна. Галуут сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Алегротовер констракшн" ХХК гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Ажлын явц 30%-тай байна.	0
113	8.1.1	Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломжийг бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аюулын эрсдэл өндөртэй сумдад байгуулна.			Сэрэмжлүүлэг мэдээний тоо	2020 он		2021	Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхийг бэхжүүлнэ.	Цаг агаар муудах бүрт alarm.tsag-agaar.mn сайтад 4 удаа анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээ оруулж малчид, иргэдэд мэдээлсэн. Цаг агаарын аюултай үзэгдлийн бүртгэл, судалгааг 1 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл гарган Цаг уур орчны шинжилгээний газрын урьдчилан мэдээлэх хэлтэст явуулсан. Нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээ, хоногийн сэрэмжлүүлэг мэдээ, урьдчилан сэргийлэх мэдээний чанар 96,3 хувь, онч 99.4 хувь, аюултай үзэгдэл болон гамшигт үзэгдлийг илрүүлсэн байдал 100 хувьтай байна.	70
114	8.1.2	Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэнэ.		-	Нислэгийн тоогоор	2020	Сард 4 удаа нислэг хийж байсан.	2021	Нислэгийн үйл ажиллагааг тогтмолжуулна.	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 116.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нисэх буудлын фасадыг засварласан. "Aeromongolia" ХХК нь 2021 оны 06 дугаар сар хүртэл долоо хоногт 1 удаа нислэг үйлддэг байсан ба Коронавирусын цар тахал болон нисэх буудлын барилгын засвартай холбоотойгоор нислэгийн үйл ажиллагааг зогсоосон. Ирэх оноос Нислэгийн үйл ажиллагааг бүрэн тогтмолжуулахаар төлөвлөн ажиллаж байна	31

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
115	8.1.3	Инновац, дэвшилтэт техник технологи, дижитал шилжилтийг АТУТөвд нэвтрүүлж ухаалаг тээврийн нэгдсэн тогтолцоог хангуулж ажиллана.	Орон нутгийн замын сан	40%	Авто тээврийн салбарын иргэдийн ая тухтай зорчих нөхцөл хангагдсанаар	2020	Нийтийн тээврээр байгаа иргэд гар утас, компьютер ашиглан хүссэн үедээ хот хооронд зорчих тасалбараа www.transdep.mn сайтаар бичүүлэх боломжтой байсан	2021	Ачаа тээврийн авто машинуудад QR код нэвтрүүлж тогтмол хяналт шалгалт явуулдаг болно. Аймгийн төвийн доторхи нийтийн тээврийн үйлчилгээнд цахим зорчих тасалбар ашиглаж эхэлнэ.	Баянхонгор аймагт ачаа тээвэрлэж байгаа авто машин бүрт QR код олгож хот, аймаг хооронд ачаа тээвэрлэлт хийх бүрт www.teeverzuuch.mn сайтад бүртгэлжүүлэн ажилласан. Мөн ачаа тээврийн logistic.transdep.mn програмд давхар бүртгэж замын хуудас болон QR кодыг олгож тээвэрлэлтэд хяналт хамгаалалт тавьж байсан. QR кодыг олгож ажилласнаар хяналт өндөрсөж ачаа тээврийн үйл ажиллагааг зохион байгуулж иргэдийн ачаа мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэсэн. Энэ нь Корона-Вирус цар тахлын үед аймгийн иргэн, аж ахуйн нэгж хүнсний хомсдолд орохгүй байх үндэслэл болсон. Баянхонгор аймгийн төвийн доторхи нийтийн тээврийн үйлчилгээний зориулалттай 4 чиглэлд 8 Эко автобус явуулсан. Ингэснээр иргэдийн ая тухтай зорчих боломж бүрдсэн бөгөөд энэ онд эко автобусанд цахим зорчих тасалбар нэвтрүүлэх судалгаа хийгдсэн.	31
116	8.1.4	Зарим сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.			Сумын тоогоор	2020		2021	Өлзийт, Эрдэнэцогт, Галуут сумдыг Шинэ сум төсөлд хамруулана.	Өлзийт суманд сумын төвийн шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэн 2021 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан. Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлыг "Бридж бюлдинг" ХХК, Галуут сумын төвийн шинэчлэлийн ажлыг "Алегровотер констракшн" ХХК тус тус гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн бөгөөд ажлын явц 30%-тай байна.	70
117	8.1.5	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах, усны бохирдол хомсдолыг бууруулж ажиллана			Худаг гаргасанаар	2020		2021	Баянхонгор сумын ундны усны эх үүсвэрт худаг гаргана	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газар, Рашаан судлалын төв, Ус, цаг уур орчны шинжилгээний хүрээлэн, Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн усны төв, Хими технологийн хүрээлэнгийн хамтарсан багийн 2010 оны судалгаагаар тогтоогдсон 13 рашааны хамгаалалтын бүсийг тогтоож сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Заг сумын Халиут, Ус, цаг уур орчны шинжилгээний хүрээлэн, Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн усны төв, Хими технологийн хүрээлэнгийн хамтарсан багийн 2010 оны судалгаагаар тогтоогдсон 13 рашааны хамгаалалтын бүсийг тогтоож сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Заг сумын Халиут,	31
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
118	8.1.6	Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдыг дагуул сум болгон хөгжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулна.			Хүн амын шилжилт хөдөлгөөн, сумын хүн амын тоогоор	2020		2021	Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдыг дагуул сум болгон хөгжүүлнэ.	Өлзийт суманд сумын төвийн шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэн 2021 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан. Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Бридж бюлдинг" ХХК гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Ажлын явц 30%-тай байна.	31
119	8.1.7	Олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.			Олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн зам барих газар болон бусад		600 м унадаг дугуйн зам баригдсан.	2021	Стандартад нийцсэн унадаг дугуйн замыг БХР аймгийн тойруулан хийх	Стандартад нийцсэн унадаг дугуйн замыг Баянхонгор сумыг тойруулан хийх судалгаа хийгдсэн. Одоогоор Оготнотой булгийн зам дагуу 600м талбайд унадаг дугуйн зам барих ажлыг Их Богд зам ХХК бүрэн гүйцэтгэсэн. 2022 онд Баянхонгор аймагт 1.3 км талбайд унадаг дугуйн зам барихаар төлөвлөж хөрөнгийн асуудлыг судалж байна.	31

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
120	8.1.8	Залуус хороолол болон Шинэ суурьшлийн бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.		Улсын төсөв, аймгийн ОНХС	Цэвэр ус, бохир ус, цахилгаан, холбоо, дулааны шугамын урт /м/	2020	Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг магадлалаар	2021	Зай талбай байгаа хэсэгт унадаг дугуйны зам барих	Шинэ суурьшлын бүсийн цэвэр усан хангамжийн 4,5 км шугам сүлжээ, хоногт 500м3-ийн хүчин чадалтай усан сангийн ажлыг эхлүүлээд байна. Мөн 128м3-ийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулаад байна.	70
121	8.1.9	Аймгийн ашиглалтын шаардлага хангахааргүй болсон хуучин барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх, өнгө үзэмжийг сайжруулах, гадна орчны тохижилт хийх, инженерийн шугамыг шинэчлэх, оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж үйлчилгээг СӨХ-д			Цэвэр ус, бохир ус, цахилгаан, холбоо, дулааны шугамын урт /м/	2020	Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг магадлалаар оруулан батлуулсан	2021	Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлсэн байна.	Баянхонгор сумын 10 дугаар байрыг дахин төлөвлөлтөд оруулахаар гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер зарлаж "Зүүн шанд" ХХК-тай гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. Тус барилга нь 2022 оны 07 дугаар сард байнгын ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн Баянхонгор сумын 510 дугаар байрны засварын ажлын гүйцэтгэгчээр "Алегротонер констракшн" ХХК, 512 дугаар байрны засварын ажлын гүйцэтгэгчээр "Түйн долгио" ХХК-иуд хийж гүйцэтгэн ашиглалтад оруулаад байна.	70
122	8.1.10	Малын чанар, ашиг шимийг сайжруулах, малын тоог чанарт шилжүүлж "Монгол мал-2", "Монгол малчин" үндэсний хөтөлбөрүүдийг		Улс, аймгийн төсөв	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөн	2020	Монгол мал-2 хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 94 хувь, 5 худаг шинээр	2022	Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.	"Монгол мал-2" үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүх төрлийн малын сүргийн эргэлт, төлөвлөлтийг тооцон ажиллаж байна. Баянбулаг омгийн хонь, Бөмбөгөрийн улаан омгийн ямааны үржлийн ажлын стратеги, төлөвлөгөөг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар батлуулан,	70
123	8.1.11	Бэлчээр ашиглалт хамгаалалтыг сайжруулж, өнжөөж чөлөөлөх, усжуулах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг үе шаттай зохион		Улс, аймгийн төсөв	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан малын тоо	2020	Монгол мал-2 хөтөлбөрийн хүрээнд 1 00 мянган га-д бэлчээрийн хортон мэрэгчтэй	2021	Жил бүр 3-аас доошгүй худаг уст цэг гаргах, 50-аас доошгүй мянган га-д	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 150 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянлиг, Баянговь, Богд, Баян-овоо, Жаргалант сумдад "Инженерийн хийцтэй 5 худаг" гаргах тендерт "Чорьж Бүрд" ХХК шалгарч ажлыг гүйцэтгэн ашиглалтад оруулснаар нийт 7500 га бэлчээр усжуулагдаж,	70
124	8.1.12	Усралтын системийг бүрэн ажиллуулж тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулж, малын тэжээлийн ургамал тариалж дотоодын хэрэгцээг ханган, газар тариалан эрхлэлтийг		Улс, аймгийн төсөв	Тариалсан талбайн хэмжээ /га/, Хураан авсан ургац /тн/	2020	614 га-д тариалалт хийж, 3500 тн ургац хураан авсан.	2021	Тариалалт ургац хураалтыг өмнө оноос нэмэгдүүлсэн байна.	Усралтын системүүдийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр сумдад зөвлөмж хүргүүлэн, ашиглалтын байдалтай нь газар дээр нь танилцаж бүртгэлжүүлэх ажлыг хийсэн. Мөн засварлах шаардлагатай системүүдийг засвар шинэчлэлт хийх төсөв тооцоог боловсруулсан. Буцагаан сумын Өлзийт, Баян, Баянлиг сумын Лигийн голын усралтын системүүдийг сайжруулж засаж сэлбэх зорилгоор 50.0 сая төгрөгийн	31
125	8.1.13	Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж		Улс, аймгийн төсөв	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан малын тоо	2020	3,3 сая толгой мал	2021	Жил бүр 2,0 сая толгой мал хамруулна.	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 2,2 сая толгой мал, амьтан хамруулахаас 2,1 сая толгой хамруулж 98,7 хувийн гүйцэтгэлтэй, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 3,8 сая толгой мал, амьтан хамруулахаас 2,8 толгой мал, амьтан хамруулж 73 хувийн гүйцэтгэлтэй байна. Олон улсын худалдааны хорио цээрт гол халдварт шүлхий	31

[1] "..... аймгийг 2021 - 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн зорилго, зорилт, арга хэмжээг бичнэ.

[2] Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой тухайн жилийн зарцуулсан, зарцуулахаар төсөвлөсөн үйл ажиллагааны зардлын дүнг бичнэ.

[3] Тухайн арга хэмжээ үр дүнд хүрсэн эсэхийг нотлохуйц шалгуур үзүүлэлтийг томъёолон бичнэ.

[4] Арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхээс өмнө түвшинг харгалзах шалгуур үзүүлэлтээр тооцон, харгалзах хугацааны хамт бичнэ.

[5] Бодлогын зорилт, арга хэмжээний үе шатуудад хүрэхээр зорьж буй түвшинг харгалзах шалгуур үзүүлэлтээр тооцон хугацааны хамт бичнэ.

[6] Тухайн арга хэмжээний хэрэгжилт, хэрэгжилтийн явцын талаар 2000 тэмдэгтэд багтаан тайлагнан бичнэ.

[7] "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2 дахь хэсгийг үндэслэн тооцно.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
---	---	---	---	---	---	---	---	---	----	----	----

Соёлын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, өсвөр үе залуучуудад сурталчлан таниулах, соёлын салбарын хүний нөөцийг чадавхижуулна. [8] Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхээр ямар нэг арга хэмжээ аваагүй, авсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй, зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой судалгаа, шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр бичих ба энэ нь дараагийн шатны төлөвлөлтөнд харгалзан үзэх чухал үзүүлэлт болно. Үүнээс гадна тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой учирч буй хүндрэл бэрхшээл, хүндрэлийг засахтай холбоотой саналыг бичиж болно.

“..... АЙМГИЙГ 2021 - 2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ” -ИЙН
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Шалгуур үзүүлэлт[1]	Хэмжих нэгж[2]	Суурь түвшин[3]		Зорилтот түвшин[4]		Тайлант хугацааны хүрсэн түвшин[5]	Мэдээлэл цуглуулах арга зүй, эх үүсвэр[6]	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)[7]
			Он	Түвшин	Он	Түвшин			
0	1	2	3	4	5	6	7	8	9
								

[1] "..... аймгийг 2021 - 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг бичнэ.

[2] "..... аймгийг 2021 - 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг бичнэ.

[3] "..... аймгийг 2021 - 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн түвшинг харгалзах оны хамт бичнэ.

[4] "..... аймгийг 2021 - 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг эхний үе шатны байдлаар бичнэ.

[5] Шалгуур үзүүлэлтийн тухайн тайлант хугацаанд хүрсэн түвшинг бичих ба 2021 оны IV улирлын байдлаар тайлагнана.

[6] Тухайн шалгуур үзүүлэлтийн мэдээлэл ямар арга зүй, аргачлалаар хаанаас, хэрхэн гардаг болон хэдий хугацаанд гаргах боломжтойг тайлбарлан бичнэ.

[7] Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар бичих ба энэ нь дараагийн шатны төлөвлөлтөд харгалзан үзэх чухал үзүүлэлт болно. Үүнээс гадна учирч буй хүндрэл бэрхшээл, хүндрэлийг засахтай холбоотой арга хэмжээний саналыг бичиж болно.